

Австрали- Монголын эрдэс баялгийн
салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр

Монгол улсын Үндэсний геологийн алба

*Олон улс дахь геологийн
албадын бүтэц загварын
үнэлгээ, зөвлөмжүүд*

Товчлол

АМЭБСХАХ	Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр
АСИ	Адам Смит Интернейшнл
БКМГА	Бритиш Колумб мужийн геологийн алба
ХГБНХ	Холбооны геологи, байгалийн нөөцийн хүрээлэн (Bundesanstalt für Geowissenschaften und Rohstoffe)
БритГА	Британийн геологийн алба
ФГА	Францын геологийн алба (Bureau de Recherches Géologiques et Minières)
ГТЛ	Геологийн төв лаборатори
ГТА	Геологийн төв алба (Тайвань)
ХятГА	Хятадын геологийн алба
ЧГА	Чехийн геологийн алба
АГХХЯ	Австралийн гадаад хэрэг, худалдааны яам
БотГА	Ботсвани улсын геологийн алба
ГАМЕГ	Геологи, ашигт малтмалын ерөнхий газар, Вьетнам
АГА	Австралийн геологийн алба (Geoscience Australia)
ГСТ	Геологийн судалгааны төв
ЗГ	ЗГ (Монгол)
КГА	Канадын геологийн алба
НамГА	Намиби улсын геологийн алба (ГА-Намиби)
ЯпГА	Японы геологийн алба
БАМГА (ФинГА)	Баруун Австрали мужийн геологийн алба Финляндын геологийн алба (Geologian Tutkimuske)
СЯ	Сангийн Яам
ГУУЯ	Геологи, уул уурхайн яам
УУЯ	Уул уурхайн яам
АМГ	Ашигт малтмалын газар
ҮГА	Үндэсний геологийн алба (Монгол)
ГТГ	Газрын тосны газар
ШГА	Шведийн геологийн алба (ШГА) Sveriges Geologiska Undersökning
УБ	Улаанбаатар
АНУГА	АНУ-ын Геологийн алба

Жич: “Geoscience” гэснийг “Геологи” гэж орчуулсан бөгөөд өргөн утгаараа “Гео-шинжлэх ухаан” гэж ойлгож болно.

Агуулга

Хураангуй	3
1. Үндэсний геологийн албаны үндсэн чиг үүрэг	9
2. Үндэсний геологийн албадын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны үнэ цэнэ, ач холбогдол	10
3. Олон улсын геологийн албадын загвар	133
4. Үр дүнгийн тойм болон Монгол улсад хандсан зөвлөмжүүд	133
5. Эдийн засгийн үндэслэл, эрх зүйн статус болон үйлчилгээ ханган нийлүүлэлт	14
6. Төрийн санхүүжилт болон орлогын бусад эх үүсвэр	14
7. Үндэсний хэмжээний үйл ажиллагаа	16
8. Геологийн мэдээлэл – Эрх, үүргүүд	17
9. Геологийн албан дахь ур чадвар, чадавхи болон дэмжих үйлчилгээ	17
10. "Загвар геологийн алба" болон үүний "боломжит бүрэлдэхүүн хэсгүүд"	18
11. Гадаад орнуудын геологийн албад	21
12. Дүгнэлт	72
Хавсралт 1: Хамаарах яамны бүтэц дэх геологийн албаны статус	74
Хавсралт 2: Сонгон авсан геологийн албад – Байгууллагын бүтэц	89
Хавсралт 3: Шведийн геологийн албанаас ирүүлсэн албан ёсны хариу	102

Хураангуй

Энэхүү судалгаа нь олон улс дахь геологийн албадын загварт үнэлгээ хийж, Монгол улсад Үндэсний геологийн алба байгуулахад ашиглах боломжит сонголтуудад дүн шинжилгээ хийн, үр дүнг танилцуулах зорилгоор бэлтгэгдсэн болно. Тус тайланд доор дурдсан улсуудын геологийн албадын тухай мэдээллийг багтаан оруулсан. Үүнд:

	Улс/Муж	Геологийн алба
1	Австрали	Австралийн геологийн алба (АГА)
2	Баруун Австрали муж	Баруун Австрали мужийн геологийн алба (БАМГА)
3	Канад	Канадын геологийн алба (КГА)
4	Бритиш Колумб муж	Бритиш Колумб мужийн геологийн алба (БКМГА)
5	Ботсвани	Геологийн судалгааны газар (Ботсвани- ГСГ)
6	Намиби	Намиби улсын геологийн алба (ГА-Намиби)
7	Вьетнам	Геологи, ашигт малтмалын ерөнхий газар (ГАМЕГ-Вьетнам)
8	Чех	Чехийн геологийн алба (ЧГА)
9	Швед	Шведийн геологийн алба (ШГА)
10	Финлянд	Финляндийн геологийн алба (ФинГА)
11	Япон	Японы геологийн алба (ЯпГА)
12	Хятад	Хятадын геологийн алба (ХятГА)
13	Казахстан	Казгеологи хамтарсан компани
14	АНУ	АНУ-ын Геологийн алба
15	Чили	СЕРНАГЕОМИН (SERNAGEOMIN) – Үндэсний геологи, уул уурхайн үйлчилгээ
16	Тайвань	Тайванийн геологийн төв алба

Тайлангийн гол үр дүн:

- Судалгаанд хамрагдсан ихэнх геологийн албад нь тухайн улсынхаа эрдэс баялгийн, байгаль орчны, эсвэл аж үйлдвэр, инновацийн асуудал хариуцсан яамдын харьяа газар буюу агентлагын хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна;
- Ихэнх геологийн албад нь тухайн асуудлыг хариуцсан сайд эсвэл төрийн нарийн бичгийн даргад ажил үүргээ шууд тайлагнаж байна;
 - Бүх геологийн албад нь зөвхөн өөрийн хамаарах яамны чиг үүргээс гадна өөр олон чиг үүргийг гүйцэтгэж байна.
- Судалгаанд хамрагдсан бараг бүх албад нь геологийн зураг, тайлан, тоон мэдээлэл борлуулах үйл ажиллагаа, мөн төрийн бусад яам, агентлагуудад үзүүлэх зөвлөх үйлчилгээнээс нэмэлт орлого төвлөрүүлэн, тухайн орлогоо өөрөө захиран зарцуулж байна;
 - Энэхүү нэмэлт орлого нь нийт санхүүжилтийнх нь <10% - >50%-тай тэнцэж байна.
- Судалгаанд хамрагдсан бүх улсуудад шаардлагатай тохиолдолд ашигт малтмал, нүүрс болон газрын тосны хайгуул, үйлдвэрлэлийн чиглэлээр геологийн судалгаа, зөвлөгөө, мэдээллийг геологийн албанаас авч байна.
- Дээрхийн адил судалгаанд хамрагдсан бүх геологийн албад нь доорх чиглэлээр судалгааны мэдээлэл цуглуулж, түгээж байна. Үүнд:

- Газар, хөрсний тогтворжилт;
 - Зарим тохиолдолд хөдөө аж ахуй, газар ашиглалтын асуудлууд;
 - Гүний ус;
 - Барилга, бүтээн байгуулалт, тээврийн дэд бүтэц; болон/эсвэл
 - Бохирдол, байгаль орчны асуудлууд
 - Дээд боловсролын салбарт хамгийн ихээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаж байна.
- Судалгаанд хамрагдсан бүх албад нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн нөхцлийн дагуу “гуравдагч талуудаас” тайлан, мэдээлэл зэргийг тодорхой хэмжээнд (тодорхой нөхцөлтэйгээр) гаргуулан авч, архивлах, ашиглах үйл ажиллагааг гүйцэтгэж байна.
 - Бүх албад нь өөрийн хариуцах салбар, ур чадварын хувьд олон салбар, мэдлэгийг тодорхой хэмжээгээр хариуцан ажиллаж байна;
 - Дээрхийн нэгэн адил бүхий л албад нь өөрийн гэсэн дотоодын дэмжлэг үзүүлэх үйлчилгээтэй байна.
 - Ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үүрэг бүхий яамны харьяанд үйл ажиллагаа явуулдаг геологийн албад нь ихэнхдээ дижитал мэдээллийн сантай буй бөгөөд тухайн мэдээллийг интернетээр дамжуулан хэрэглэгчдэд түгээж буй тул тухайн албад нь Фрейзерийн хүрээлэнгээс гаргасан рейтингээр мэдээллийн сангийн чанараараа эхний 20%-д багтсан байна;
 - Тодорхой хэмжээгээр дижитал мэдээллийн сан бүхий албад нь зарим мэдээллийг интернетээр түгээдэг ба эдгээр албад нь дээрх рейтингээр эхний 30-40%-д багтаж байна;
 - Хязгаарлагдмал дижитал мэдээллийн сантай, багахан хэмжээний мэдээлэл түгээдэг геологийн албад нь дээрх судалгаагаар хамгийн муу үйл ажиллагаатай 10-30%-д багтах албадын тоонд эрэмбэлэгдсэн байна.
 - Энэ бүлэгт одоогоор Монгол улс багтаж байна.
 - БНХАУ (Хятадын геологийн алба): Хятад улсын эдийн засгийн хэмжээ болон цогц байдал, тус улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллагуудын хамрах цар хүрээ зэргийг авч үзвэл тус улсын геологийн салбар нь судалгаанд хамруулсан бусад улс орнуудтай харьцуулашгүй юм. Хятадын геологийн алба нь нийт 27 салбар байгууллагатайгаар үйл ажиллагаа явуулдаг. Судалгаа хийсэн багийн зүгээс Хятадын геологийн алба нь бусадтай харьцуулахад энгийн загварт хамаарахгүй, бүтцийн хувьд сайн зохион байгуулагдсан ч мэдээллийн сангийн асуудал тодорхойгүй, геологийн мэдээллийн чанарын хувьд Фрейзерийн хүрээлэнгийн 2014 онд гаргасан судалгаагаар 122 орноос 116-д эрэмбэлэгдсэн байдалтай буйг олж тогтоосон. *Хэрэглэгч геологийн мэдээллийг хэрхэн авдаг болохыг тодорхойлох нь ихээхэн хүндрэлтэй байна.*
 - Казахстан (Казахстан улсын “геологийн алба”). Тус улсад геологийн судалгааг үндэсний геологи хайгуулын компани эрхлэн явуулдаг ба энэ нь судалгаанд хамрагдсан бусад улсуудтай адилгүй юм.

Дээр дурдсан судалгаа, ажиглалт дээр үндэслэн нийт 10 цуврал зөвлөмжийг хүргүүлж байна:

Зөвлөмж 1 - Төсвийн санхүүжилт болон бусад орлого

Шинээр байгуулагдах Геологийн албаны санхүүжилтийн үндсэн эх үүсвэр нь улсын төсөв байх бөгөөд Уул уурхайн яамны төсвийн багцаас санхүүжүүлэхийн зэрэгцээ, үндсэн төсвийн бус бусад эх үүсвэрээс мөн орлого төвлөрүүлэн, тухайн НЭМЭЛТ орлогыг төсөвтөө төвлөрүүлж, үйл ажиллагаандаа зарцуулж байх боломжтой. Нэмэлт орлогын эх үүсвэрт дараах эх үүсвэрүүд багтаж болно:

- Бүх төрлийн хэрэглэгчдэд геологийн мэдээлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ ханган нийлүүлэх;
- Яам, агентлагууд болон бусад талуудад зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх.

Зөвлөмж 2 - Үндэсний хэмжээний үйл ажиллагаа

Шинээр байгуулагдах Үндэсний геологийн алба нь геологийн чиглэлээр өргөн хүрээний чиг үүрэг хэрэгжүүлж, Монгол улсын үндэсний эрх ашигт томоохон хувь нэмэр оруулж байх. Үүнд:

- Ашигт малтмалын хайгуул, үйлдвэрлэл болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд геологийн мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ ханган нийлүүлэх, МӨН;
- Үндэсний хэмжээний илүү өргөн хүрээний асуудлаар мэдээлэл, зөвлөгөө өгөх:
 - Газар, хөрсний тогтворжилт;
 - Хөдөө аж ахуй болон газар ашиглалт;
 - Гүний ус;
 - Барилга, бүтээн байгуулалт, тээврийн дэд бүтцийн чиглэлээрх инженер геологийн үйл ажиллагаа;
 - Бохирдол болон байгаль орчны асуудлууд; МӨН
- Дээд боловсролын салбарт дэмжлэг үзүүлэх.

Зөвлөмж 3 - Геомэдээлэл - эрх ба үүрэг

Ирээдүйд байгуулагдах Үндэсний геологийн алба нь Уул уурхайн яамны харьяа Агентлагийн статустай байх нь оновчтой бөгөөд үндсэн чиг үүрэгт нь улсын хэмжээний газрын тос, ашигт малтмал, нүүрс, гүний ус болон хэрэв боломжтой бол “гуравдагч талуудын” цуглуулсан геологийн мэдээлэл, тайлангууд зэрэг бүхий л гео-мэдээллийг цуглуулах, архивлан хадгалах, ашиглах (зөвшөөрөлтэйгээр) чиг үүрэг бүхий геологийн салбарын мэдлэг, мэдээллийн бат бөх суурийг үндэсний хэмжээнд бий болгох шаардлагатай. Мөн

Одоо Ашигт малтмалын газрын харьяанд үйл ажиллагаа явуулж буй Геологийн мэдээллийн төвийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид байгуулагдах Үндэсний геологийн албыг мэдээлэл архивлан хадгалах, вебд суурилсан байдлаар хэрэглэгчдэд мэдээлэл хүргэх чиг үүрэг өндөр түвшинд гүйцэтгэхэд нь бэлтгэх хэрэгтэй.

Зөвлөмж 4 - (а) Геологийн алба дахь мэргэшлийн ур чадвар, чадамж

Монгол улсын Үндэсний геологийн албанд шаардлагатай геологийн мэдлэг, мэргэшил, ур чадвар нь геологийн салбарын олон төрөл, дэд салбаруудыг хамарсан байх.

Зөвлөмж 4 - (б) Геологийн алба дахь туслах үйлчилгээ

Үндэсний геологийн албанд шаардлагатай дэмжих (туслах) үйлчилгээг улам өргөжүүлэх.

Зөвлөмж 5 - Хэрэгжилт - “Загвар геологийн алба”

Шинээр байгуулагдах Үндэсний геологийн алба нь Уул уурхайн яамны харьяа Төрийн захиргааны байгууллага, Засгийн газрын агентлаг буюу багаар бодоход өнөөгийн Ашигт малтмалын газар, Газрын тосны газрын түвшинд ижил статустай байх; *мөн*

Ашигт малтмалын газрын Геологийн судалгааны хэлтэс, Уул уурхайн судалгааны лаборатор, Хатуу түлшний судалгааны нэгж (Нүүрсний хэлтэс) зэргийг Үндэсний геологийн албанд шилжүүлэх;

түүнчлэн Газрын тосны газрын судалгаа, хайгуул, үнэлгээ болон нөөц тогтоох, архив болон мэдээллийн сангийн чиг үүргийг шинэ албанд шилжүүлэх;

мөн Геологийн судалгааны төв болон Геологийн төв лабораторийг тус албанд нэгтгэх, Соёл, шинжлэх ухааны асуудал хариуцсан яамтай тохиролцсоны үндсэн дээр Палеонтологийн хүрээлэнг нэгтгэн оруулах.

(нэмэлт) - Загвар геологийн албаны бүтцийн төсөл

Уул уурхайн яамны Ажлын хэсгийн зүгээс Үндэсний геологийн албаны загвар бүтцийг албан бус байдлаар зураглан гаргахыг хүссэн юм.

Доор дурдсан жишээ нь судалгаанд хамруулсан жижиг болон дунд хэмжээний хэд хэдэн геологийн албадын жишээн дээр суурилсан бөгөөд Үндэсний геологийн албаны бүтэц, бүрэлдэхүүнийг ерөнхийлөн, чиг үүргээр нь тусгасан. Энэхүү бүтэц нь мөн мэдээлэл түгээх чиг үүргийг гүйцэтгэхдээ тухайн үйл ажиллагаанаас төвлөрүүлсэн орлогыг өөрөө эрхлэн зарцуулдаг байхаар тусгасан болно. Эдгээрийг нэгтгэн нэг зохион байгуулалтад оруулж хэрэгжүүлэх нь урт хугацааны зорилго юм.



Зөвлөмж 6 - Үндэсний геологийн албаны санхүүжилтийн боломжит загвар

Шинээр байгуулагдах Үндэсний геологийн албаны хувьд “улсын төсөв” нь цаашид тус бүтцэд хамаарах одоо үйл ажиллагаа явуулж буй нэгжүүдийн нийт төсөв бөгөөд үүнд ажилтнуудын цалин урамшуулал, нэмэлт цалин, үйл ажиллагааны зардал, капитал зардал, албан байрны зардал болон захиргааны зардал зэргийг одоогийн хэмжээнээс нь бууруулахгүйгээр шууд шинэ албанд шилжүүлэх шаардлагатай; *мөн*

Шинээр байгуулагдах Үндэсний геологийн алба нь өөрийн үйлчилгээ, мэдээлэл зэргийг хэрэглэгчдэд зах зээлийн зохистой үнээр борлуулан, энэхүү үйлчилгээнээс төвлөрүүлсэн бүхий л орлогыг өөрөө захиран зарцуулах эрхтэй байснаар өөрийн тодорхой чиг үүргээ гүйцэтгэх, үзүүлж буй үйлчилгээгээ өргөжүүлэх, “үндэсний эрх ашигт” үйлчлэх боломжтой болно.

Зөвлөмж 7 - Эрх зүйн асуудлууд

Зарим талаар арилжааны чиглэлийн үйл ажиллагаа явуулах боломж бүхий Үндэсний геологийн алба байгуулахын тулд тухайн байгууллагыг Уул уурхайн яамны харьяаны төрийн захиргааны байгууллага, Засгийн газрын агентлагын статустайгаар эхлэн байгуулах нь зүйтэй юм. Үүнтэй уялдуулан Ашигт малтмалын тухай хуульд байгаа геологийн албаны талаарх заалтуудыг эргэн харж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүсч байна. Түүнчлэн геологи болон бусад салбарт хамаарах бусад хууль тогтоомжийг ч гэсэн нэгтгэн уялдуулан зохицуулах шаардлага гарч байна.

Зөвлөмж 8 - Үндэсний геологийн алба болон бусад яам, агентлаг хоорондын харилцаа

Өөрийн үзүүлж буй үйлчилгээг төлбөртэй хүргэхийн тулд яам хоорондын Харилцан ойлголцын санамж бичиг эсвэл гэрээ байгуулан хэрэгжүүлэх үүнд доорх асуудлыг тусгахыг санал болгож байна.

- Яам болон агентлагуудын зүгээс шаардагдаж буй Үндэсний геологийн албаны үзүүлэх үйлчилгээний цар хүрээ, хэмжээ,
- Төлбөрийн нөхцөл, үнэ тариф (улсын төсвөөс шилжүүлэх), болон
- Хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэх үүднээс Геологийн албаны баримтлах, ханган нийлүүлэх үйлчилгээний нөхцөл, шаардлагууд.

Зөвлөмж 9 - Үйлчилгээг хүргэх болон үнэ тарифын сонголтууд (Шилдэг туршлага)

Геологийн албанаас хэрэглэгчдэд үзүүлэх үйлчилгээний үндсэн үнэ тариф нь хэвлэн нийтлэгдсэн зургууд (зураг болон товхимол гэх мэт), хэвлэн нийтлэгдсэн мэдээллүүд (тайлангууд)-ийг өөрийн хамаарахаас бусад яам, агентлагууд, хувийн компаниуд, их сургууль болон олон нийтэд үнэ төлбөргүйгээр (эсвэл маш бага төлбөртэйгээр) интернетээр дамжуулан түгээхтэй уялдах ба ямар нэгэн байдлаар хуулбарлах, түгээхтэй холбоотой зардал дээр үндэслэн тооцогдох; МӨН

Хэрэглэгчийн зүгээс нэмэлт үйлчилгээ авах тохиолдолд, тухайн үйлчилгээг зах зээлийн үнээр үнэлэн хүргэх ба тухайн мэдээлэлтэй хамаарах нууцлал нь ихэнх тохиолдолд 3 жилийн хугацаа нь дуусахад олон нийтэд нээлттэй болгох.

Зөвлөмж 10 - Олон нийт, хэрэглэгчдэд хүрч ажиллах

Уул уурхайн яамны зүгээс www.ngs.gov.mn хэмээх домайн нэрийг албан ёсоор, Монголын үндэсний геологийн албыг байгуулах бэлэгдлийн алхам байдлаар бүртгүүлэн, ажиллуулах; МӨН

Үндэсний геологийн албаны бүрэлдэхүүн байгууллагууд нь тухайн сайтад мэдээлэл оруулан, Үндэсний геологийн албыг олон нийт болон хэрэглэгчдэд тайлбарлан таниулж эхлэх, юуны өмнө 1:1,000,000 масштабын геологийн зургийг оруулах замаар энэхүү үйл ажиллагааг эхлүүлэх.

1. Үндэсний геологийн албаны үндсэн чиг үүрэг

Үндсэндээ дэлхийн бүх улс орон өөрийн гэсэн геологийн албадтай байдаг бөгөөд эдгээрийн тоонд Австрали, Герман, Канад болон АНУ зэрэг Холбооны засгийн газар (муж улсуудын холбоо) бүхий улсууд ч мөн багтаж байна. Холбооны систем бүхий эдгээр улсад мужийн геологийн албад үйл ажиллагаа зэрэгцэн явуулж буй бөгөөд ихэнх тохиолдолд тэд үндэсний геологийн албаны гүйцэтгэх олон тооны чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна.

Улс бүрийн геологийн албадын үүрэг роль, чиг үүргийг дэлгэрүүлэн авч үзвэл харилцан ялгаатай буй ч тэдний үйл ажиллагааны тэнцэл нь үндсэндээ ихэнх тохиолдолд эрдэс баялгийн асуудлууд, мөн үүний зэрэгцээ байгалийн гамшиг, аюулыг бууруулах (энэ нь тухайн улсын хувьд гол асуудал буй бол), харин бусад геологийн албадын хувьд байгаль орчны асуудлууд, ялангуяа байгаль орчны хувьд эмзэг улсуудад энэ асуудлыг үндсэн чиг үүрэгтээ оруулан хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ иж бүрэн, системтэй геологийн мэдлэг болон хөрс, газрын гүний геологийн асуудлууд, эдгээрийг баримтжуулах нь судалгаанд хамруулсан бүхий л геологийн албадын хувьд үндсэн чиг үүрэг нь болж байна.

Муж улсуудын геологийн албад нь мөн доорх болон бусад чиг үүргийг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Хайгуул, уул уурхайн ашиглалтын эрх, зөвшөөрлийг удирдах, үүнийг шууд хэрэгжүүлэх чиг үүрэг хэлбэрээр зохицуулах, эсвэл
- Хайгуулын шатанд хийгдсэн геологийн тайлангуудын чанарт хяналт тавих, энэхүү чиг үүргийг хамаарах уул уурхай болон түлш эрчим хүчний асуудал хариуцсан яамтай хамтран гүйцэтгэх.
- Хайгуул, уул уурхай болон орон нутгийн хөгжлийн асуудалтай холбоотой байгаль орчны асуудлуудын сонголтуудын талаар хэлэлцүүлэг өрнүүлэх
- Геологийн үүдэлтэй аюул ослын тодорхойлолт, мониторинг
- Хот суурин газрын геологийн зураглал, инженер геологи
- Гидрогеологи болон усны менежмент

2. Үндэсний геологийн албадын бүтээгдэхүүн, үйл ажиллагааны үнэ цэнэ, ач холбогдол

Судалгааны багийн хийж гүйцэтгэсэн ажлын тайлангуудаас үзвэл геологийн албад нь ашигт малтмал нөөцийн хайгуул, олборлолтын чиглэлд томоохон хэмжээний хувь нэмрийг оруулдаг болох нь тодорхой бөгөөд тухайн албадын гаргаж буй үр ашиг болон зардлын харьцааг авч үзвэл 10:1 ба үүнээс дээш байна.

Үндэсний геологийн албаны үзүүлэх үнэ цэнэ, хувь нэмрийг илүү сайн харуулахын тулд Британийн геологийн алба болон бусад хоёр улсын геологийн албаны үзүүлж буй үнэ цэнэ, хувь нэмрийг эдийн засагт үзүүлэх нөлөө болон олон нийтэд үйлчилж буй байдлаар нь харууллаа.

2003 онд хийгдсэн Британийн геологийн албаны тухай тойм судалгаагаар эдийн засагт шууд оруулж буй үр дүнг нийт эдийн засагт оруулсан нөлөөлөлтэй нь харцуулан үзвэл Нэгдсэн Вант Улсын эдийн засагт оруулж буй хувь нэмэр нь гарч буй зардлаас нь ойролцоогоор **1000 дахин өндөр** байна гэсэн дүгнэлтийг хийжээ.

Британийн геологийн албаны зүгээс оруулж буй нийт хуримтлагдсан үр дүн нь дээр дурдсанчлан 2001 оны байдлаар 34 тэрбумаас 61 тэрбум паундтай тэнцэж буй нь Их Британийн нийт үйлдвэрлэлийн 5-8%-тэй тэнцэж байна. Энэ нь тухайн геологийн албаны жилийн санхүүгийн эргэлт болох 40 сая орчим паундын зардалтай (судалгаанд хуваарилсан зардлыг оруулаад) харьцуулахад өндөр буй билээ.

Энэхүү судалгаа нь цэвэр эдийн засгийн үнэлгээн дээр суурилсан бөгөөд “олон нийтэд” үйлчлэх хэмээх хүчин зүйл нь “өрсөлдөх давуу тал” болон “мөнгөн дүн” хэмээх үзүүлэлтээс ч хавьгүй илүү юм:

Хоёрдугаарт Британийн геологийн албаны хувьд үр дүнг нь бууруулж буй хэмээн тооцогдох өөр нэгэн чухал шалтгаан буй юм. Учир нь тухайн албанаас гаргаж буй бүтээгдэхүүний ихэнх нь зах зээлийн бус нийтийн үйлчилгээнд зориулагддаг бөгөөд үүний үзүүлж буй үнэ цэнийг мөнгөн дүнгээр хэмжин гаргахад ихээхэн хүндрэлтэй учраас тухайн үйлчилгээний биет үр дүн нь санхүүгийн баримт бичиг дээр бүртгэлгүй байдаг юм.

Австрали улсын хоёр муж болон Шинэ Өмнөд Уэльс болон Өмнөд Австрали мужуудын геологийн албадын үзүүлж буй эдийн засгийн нөлөөллийг саяхан судлан үзжээ.

ASIC Тасман (2010) компанийн зүгээс Шинэ Өмнөд Уэльс мужийн геологийн албыг судлан үзсэний дүнд доорх дүгнэлтийг гаргажээ:

Шинэ Өмнөд Уэльс мужийн эдийн засаг нь өнөө хэрэгжиж буй 'New Frontiers' санаачилгыг үргэлжлүүлэн хэрэгжүүлснээр санхүүгийн болон эдийн засгийн үр дүнг бодитоор хүртэх юм. Мужийн нийт орлогод тухайн хөтөлбөрөөс нэмж оруулах нэмэлт орлого нь 3 тэрбум Австрали доллар байх ба энэ нь хөтөлбөрийн цэвэр зардлын өнөөгийн үнэ цэнээс 43 дахин их юм.

Өмнөд Австрали мужид хийгдсэн судалгаа нь геологийн албаны Хайгуулын ажлыг нэмэгдүүлэх төлөвлөгөөг судлан үзсэн бөгөөд тухайн төлөвлөгөө нь (PACE) Австрали болон бусад улс орнуудад ашигт малтмал, газрын тосны хайгуулын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд үлгэр жишээ болохуйц хөтөлбөр хэмээн тооцогдог юм. 2014 онд Economic Consulting Services компанийн хийсэн судалгаагаар (2014) PACE төлөвлөгөөний талаар доорх дүгнэлтийг гаргасан байна:

- Төлөвлөгөөний дагуу ойролцоогоор 50 сая долларыг хэд хэдэн жилийн туршид зарцуулах бөгөөд үүний үр дүнд мужийн уул уурхайн салбараас олох орлого 2400 сая доллараар нэмэгдэнэ;

- Төлөвлөгөө нь томоохон хэмжээний зэс-алтны нөөцийг Карратена бүсэд олж илрүүлэх, тухайн судалгаан дээрээ үндэслэн Камсины зэс-алтны ордыг мөн нээсэн;
- Өмнөд Австрали мужид хайгуулын чиглэлээр нэмэлт 700 сая долларын хөрөнгө оруулалтыг татсан;
- Хайгуулд зарцуулж буй мөнгө нь өмнө хэрэгжиж байсан геологийн хөтөлбөртэй харьцуулбал 20 дахин нэмэгдсэн.

Дэлхийн хэмжээнд Фрейзерийн Хүрээлэн нь Уул уурхайн компаниудын талаар жил тутмын судалгаа хийдэг бөгөөд ойролцоогоор 4200 хайгуул, олборлолт болон бусад уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудад тухайн судалгааны асуултыг илгээдэг. Энэхүү судалгаа нь дэлхийн 100 гаруй улсын уул уурхай, эрчим хүчний эх үүсвэрт хөрөнгө оруулалт татах боломжийг судалдаг. Энэхүү судалгааны нэг хэсэг нь хөрөнгө оруулалтыг татахад геологийн мэдээллийн нээлттэй байдлыг үнэлдэг. Тиймээс тухайн улс орны геологийн салбарын үйл ажиллагааг энэхүү судалгаанд дурдсан зэрэглэлийг ашиглан үнэлэх боломжтой юм. Хувиар авч үзвэл 2014 онд Финлянд, Өмнөд Австрали, Саскатчеван, Шинэ Брунсуик (Канадын мужууд) болон Баруун Австрали зэрэг муж, улсууд нь нийт 122 улсаас эхний 5-д орсон бөгөөд бүгд 100 оноо авсан бол Судан, Өмнөд Судан улсууд 0 оноотой байна.

Геологийн мэдээллийн сангийн талаарх Фрейзерийн Хүрээлэнгийн судалгааг доор үзүүлсэн бөгөөд энд тухайн улс/мужуудыг Монгол улстай харьцуулан харууллаа. Ийнхүү харьцуулж үзвэл 2015 онд нийт 109 улсыг, харин 2014 онд нийт 122 улсыг тухайн судалгаанд хамруулсан байна. Судалгаанд хамрагдсан орнуудаас Австрали, Финлянд болон Швед улсууд дээгүүр байраа хадгалж буй бол Канад болон АНУ дундаас дээгүүр, Намиби болон Ботсвани улсууд дунд хавьд байна. Өмнөх жилүүдтэй харьцуулбал зарим улс орнууд зэрэглэл дээшилсэн буй бөгөөд жишээ нь Швед 10 дугаар байраас 1 дүгээрт, Чили 46 дугаар байрас 26-д, Казахстан 114 дүгээр байраас 55-д дэвшин орсон бол бусад улсууд нь өмнөх оны байраа хадгалсан хэвээр байна. Монгол улсын хувьд 96 дугаар байраас бага зэрэг урагшилж 80 дугаарт эрэмбэлэгджээ. Монгол улс нь “сайжруулах боломжтой” гэсэн улсууд дундаа 4 дүгээрт орсон байна.

Энэхүү олон улсын жишиг тодорхойлох судалгаанд ашигласан 2014, 2015 онуудын үр дүнг доор харууллаа:

Геологийн мэдээллийн сангийн үйлчилгээ		Зэрэглэл	
		2014 (122 орон)	2015 (109 орон)
1	Баруун Австрали	5	3
2	Австралийн бусад мужууд	2 - 21	5-18
3	Швед	10	1
4	Финлянд	1	2
5	Бритиш Колумб, Канад	14	16
6	Канадын бусад муж, газар нутгууд	3 – 51 (Nunavut)	4-45 (Nunavut)
7	Намиби	39	39
8	Ботсвани	48	46
9	Вьетнам	86	104
10	Монгол	96	80
11	АНУ	15 - 49	8 – 44
12	Казахстан	114	55
13	БНХАУ	116	100
14	Чили	46	26

Дээрх судалгаанд Австрали болон Канадын Холбооны геологийн албадыг хамруулаагүй бөгөөд учир нь зөвхөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий улс орнууд, мужуудыг энэхүү судалгаанд хамруулжээ. Түүнчлэн уул уурхайн чиглэлийн үйл ажиллагаа доогуур, бага хэмжээнд байдаг тул Чех, Япон болон Тайвань улсуудыг ч зэрэглэлд оруулаагүй байна. Вьетнам улсын хувьд тоон технологид хөрөнгө оруулалт хийх чиглэлээр үр дүн муутай буй нь тус улсын мөн доогуур

зэрэглэлд хамруулахад хүргэжээ. Түүнчлэн Хятадын геологийн албаны хувьд алба нь тус улсын геологийн мэдээллийн хамгийн гол эх үүсвэр хэдий ч мэдээлэл түгээх тал дээр тун муу үйл ажиллагаа явуулдаг нь Хятадын геологийн албыг 122 орноос 116 дугаарт эрэмбэлэгдэхэд хүргэжээ. Хятадын геологийн алба нь аналог болон дижитал мэдээллийг түгээх тал дээр маш дутмаг байгаа нь харагдаж байна.

Дээрхээс үндэслэн мэргэжлийн геологийн алба болон иж бүрэн, хүртээмжтэй геологийн мэдээлэл нь ашигт малтмалын салбарын хөрөнгө оруулалтын боломжууд болон энэ чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээг сайжруулах үндсэн нөхцөл хэмээх дүгнэлтэд хүрч байна.

Геологийн судалгааны мэдээллийн сан нь “хөрөнгө оруулалт татах боломж” хэмээх нийтлэг үзүүлэлтийн цорын ганц хүчин зүйл байхын зэрэгцээ Монгол улсын хувьд ч энэ нь богино хугацаанд сайжруулах боломжтой салбар болох нь харагдаж байна.

3. Олон улсын геологийн албадын загвар

Доор дурдагдсан үндэсний геологийн албадыг энэхүү тайланд зориулан үнэлгээ хийн, судлан үзлээ:

	Улс/Муж	Геологийн алба
1	Австрали	Австралийн геологийн алба (АГА)
2	Баруун Австрали муж	Баруун Австрали мужийн геологийн алба (БАМГА)
3	Канад	Канадын геологийн алба (КГА)
4	Бритиш Колумб муж	Бритиш Колумб мужийн геологийн алба (БКМГА)
5	Ботсвани	Геологийн судалгааны газар (Ботсвани- ГСГ)
6	Намиби	Намиби улсын геологийн алба (ГА-Намиби)
7	Вьетнам	Геологи, ашигт малтмалын ерөнхий газар (ГАМЕГ-Вьетнам)
8	Чех	Чехийн геологийн алба (ЧГА)
9	Швед	Шведийн геологийн алба (ШГА)
10	Финлянд	Финляндын геологийн алба (ФинГА)
11	Япон	Японы геологийн алба (ЯпГА)
12	Хятад	Хятадын геологийн алба (ХятГА)
13	Казахстан	Казгеологи хамтарсан компани
14	АНУ	АНУ-ын Геологийн алба
15	Чили	СЕРНАГЕОМИН (SERNAGEOMIN) – Үндэсний геологи, уул уурхайн үйлчилгээ
16	Тайвань	Тайванийн геологийн төв алба

4. Үр дүнгийн тойм болон Монгол улсад хандсан зөвлөмжүүд

4.1 Монгол улсын геологийн салбарын өнөөгийн байдал

Үндсэн хүчин зүйлс:

- 1:200,000 масштабын геологийн зураглалаар Монгол улсын нутаг дэвсгэрийг 100% хамруулсан;
- 1:50,000 масштабын геологийн зураглалыг нийт нутаг дэвсгэрийн 30-40%-д хийж гүйцэтгэсэн;
- Төрөл бүрийн масштаб бүхий геофизикийн судалгааг хийж гүйцэтгэсэн - ~40%;
- Регионал гидрогеологийн судалгаа– 84%;

Геологийн судалгаа хийгдсэн нийт нутаг дэвсгэрийн хувь хэмжээ нь дээрх 4 хүчин зүйлсийн хувьд дунджаар 60 орчим хувь хүрээд байгаа бөгөөд судалгааны олон тооны төсөл хөтөлбөр мөн хэрэгжиж байна.

2016 оны байдлаар тусгай зөвшөөрлөөр хуваарилсан талбайн нийт хэмжээ нь нийт газар нутгийн 9.4% (14.7 сая га) болоод буй бөгөөд үүнд хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь 8.6% (13.4 сая га), олборлолтын тусгай зөвшөөрлийн талбай нь 0.8% (1.33 сая га) байна.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох боломжтой нийт газар нутгийн хэмжээ нь нийт нутгийн 20.9% (32.6 сая га), харин ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон нийт газар нутгийн хэмжээ нь 69.6% (108.6 сая га) байна.

5. Эдийн засгийн үндэслэл, эрх зүйн статус болон үйлчилгээ ханган нийлүүлэлт

Үндсэндээ дэлхийн бүх улс орон өөрийн гэсэн геологийн албадтай байдаг бөгөөд эдгээрийн тоонд Австрали, Герман, Канад болон АНУ зэрэг Холбооны засгийн газар (муж улсуудын холбоо) бүхий улсууд мөн багтаж байна. Холбооны систем бүхий эдгээр улсад мужийн геологийн албад мөн үйл ажиллагаа явуулж буй бөгөөд ихэнх тохиолдолд тэд үндэсний геологийн албаны гүйцэтгэх олон тооны чиг үүргүүдийг хэрэгжүүлж байна.

Улс бүрийн геологийн албадын үүрэг роль, чиг үүргийг дэлгэрүүлэн авч үзвэл харилцан ялгаатай буй ч тэдний үйл ажиллагааны тэнцэл нь үндсэндээ ихэнх тохиолдолд эрдэс баялгийн асуудлууд, мөн үүний зэрэгцээ байгалийн гамшиг, аюулыг бууруулах (энэ нь тухайн улсын хувьд гол асуудал буй бол), харин бусад геологийн албадын хувьд байгаль орчны асуудлууд, ялангуяа байгаль орчны хувьд эмзэг улсуудад энэ асуудлыг үндсэн чиг үүрэгтээ оруулан хэрэгжүүлж байна. **Гэсэн ч иж бүрэн, системтэй геологийн мэдлэг болон хөрс, газрын гүний геологийн асуудлууд, эдгээрийг баримтжуулах нь судалгаанд хамруулсан бүхий л геологийн албадын хувьд үндсэн чиг үүрэг нь болж байна.**

Судалгаанд хамрагдсан ихэнх геологийн албад нь хамаарах **яамны сайдад шууд харьяалагдах** агентлаг, газар байдлаар, ихэнх тохиолдолд тухайн газрын дарга нь сайдын өмнө ажлаа тайлагнаж байна.

Монгол улсын хувьд газрын тос, ашигт малтмал болон нүүрсний хайгуул, олборлолтыг харгалзан үзвэл геологийн асуудлыг хариуцсан үндсэн байгууллага нь Уул уурхайн яам байх нь зүйтэй. Энэ нь үндэсний геологийн алба байгаль орчин болон байгалийн гаралтай гамшиг (олон нийтийн аюулгүй байдал)-тай хамаарах асуудлуудыг ойлгох, шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах чиг үүргийг нь бууруулахгүй юм. Дэлхий нийтийн геологийн салбар дахь Монгол улсын байр суурь нь мөн Мезозойн эриний сайтар хадгалагдан үлдсэн сээр нуруутны олдвортой мөн холбоотой билээ.

6. Төрийн санхүүжилт болон орлогын бусад эх үүсвэр

Геологийн албадын санхүүжилтийн хэлбэр болон эх үүсвэр олон төрөл байгаа ч судалгаанд хамрагдсан бүхий л албад нь **Төрөөс өөрийн үндсэн санхүүжилтийг авч буй** бөгөөд жил тутмын төсөв нь хамаарах яамных нь төсвийн багцад хамаарч байна. Судалгаанд хамрагдсан бүх геологийн албад өргөн хүрээний хэрэглэгчдэд төрөл бүрийн мэдээлэл, зөвлөх үйлчилгээг борлуулах боломж нээлттэй буй бөгөөд тухайн байгууллагуудын хамаарах яамны цар хүрээнээс гадагш ч тухайн мэдээлэл үйлчилгээг төлбөртэйгээр ханган нийлүүлж байна. Ийнхүү үндсэн төсвөөс гадуур орлого төвлөрүүлэх хэлбэр нь өөрийн төсөвт нэмэр болж, үзүүлж буй үйлчилгээг илүү өргөн хүрээнд төрийн байгууллагууд, аж үйлдвэрийн салбарын оролцогчид болон олон нийтэд хүргэж байна.


Шинээр байгуулагдах Үндэсний геологийн албаны төсвийн үндсэн санхүүжилтийг Улсын Их Хурлаас баталгаажуулан, батлаж, Сангийн Ямаар дамжин шууд хамаарах яамны буюу Уул уурхайн яамны багцад хуваарилдаг байх ёстой. Төрөөс олгож буй энэхүү санхүүжилтээс гадна өөрийн мэргэжлийн үйлчилгээг ханган нийлүүлсний үндсэн дээр олж төвлөрүүлсэн орлогыг нэмэлтээр тус байгууллагад олгон үйл ажиллагаанд нь зарцуулах шаардлагатай. Эдгээрт дараах нэмэлт орлогын эх үүсвэрүүд хамаарна. Үүнд:

- (а) Геологийн мэдээлэл болон бүтээгдэхүүн борлуулсаны орлого (Үндэсний геологийн албанаас төр, сургалт, судалгааны байгууллагууд болон бусад салбарт хандан үзүүлж буй үйлчилгээ нь тус албанаас үзүүлж буй зураг, тайлан болон тоон мэдээлэл зэрэг бүтээгдэхүүнийг олшруулах болон хүргүүлэх зэрэг зардлыг шингээсэн тогтмол төлбөртэй байх нь тус албаны өмнөө тавьсан зорилгод нийцнэ);*
- (b) Бусад яамд, төрийн байгууллагуудад өгөх зөвлөгөө болон үзүүлсэн үйлчилгээний орлого (тухайн төсөл бүр дээр хийгдсэн гэрээний дагуу, талуудын харилцан тохирсон үнээр тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлэх. Тухайн мэдээлэл, үйлчилгээний үнэ нь эдийн засгийн хувьд гарах зардлыг бүрэн нөхсөн хэмжээнд байснаар Үндэсний геологийн алба нь бат бөх суурь бүхий байгууллага болох боломжтой); мөн*
- (c) Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын хөгжлийн байгууллагуудад тухайн хэрэгжүүлж буй төсөл бүрээр нь хийгдэх гэрээний үндсэн дээр үзүүлэх зөвлөгөө болон үйлчилгээ. Энэхүү үйлчилгээг мөн эдийн засгийн хувьд ашигтай үнээр борлуулсанаар Үндэсний геологийн албанаас үзүүлэх үйлчилгээ, хувь нэмэр өсөх юм.*

Монгол улсын Уул уурхайн яамны зүгээс төслийн багт хандан тухайн судалгаанд хамрагдсан улсын засгийн газруудын зүгээс геологийн салбар, геологи хайгуулын ажлыг хэрхэн санхүүжүүлдэг талаар судлан үзэх хүсэлтийг гаргасан юм. Судалгааны баг нь улсын төсвөөс хуваарилах төсвийн санхүүжилт болон нэг хүнд ногдох худалдан авах чадварын ДНБ-ний хэмжээний хамаарал нь тухайн үзүүлэлтийг харуулах хамгийн боломжит үзүүлэлт хэмээн тооцон үзсэн болно. Тайвань, Ботсвани болон Вьетнам улсын Засгийн газраас геологи хайгуул, судалгааны чиглэлээр хуваарилж буй төсвийн талаар мэдээлэл олдоогүй. Статистикийн хувьд хүчин төгөлдөр, бүрэн илэрхийлэх дүр зургийг харуулахын тулд Нэгдсэн Вант Улс, Өмнөд Африк болон Монгол улсуудыг нэмж орууллаа.

Үүнээс бид доорх зүйлсийг ажигласан болно:

- Намиби улсын хувьд төсвөөс олгож буй үндсэн санхүүжилт нь маш бага хэмжээтэй ч төсвийн бус эх үүсвэрээс төвлөрүүлэх орлогоос санхүүжилтын ихээхэн хувийг бүрдүүлдэг;
- Монгол улсын хувьд геологийн салбарт хуваарилж буй төсвийн хэмжээ маш доогуур буй бөгөөд ерөнхий регрессийн шугамд хүргэхийн тулд санхүүжилтийн хэмжээг 16 сая орчим ам доллар хүртэл өсгөхөөр харагдаж байна.



7. Үндэсний хэмжээний үйл ажиллагаа

Судалгаанд хамрагдсан геологийн албадын дийлэнх нь **ашигт малтмалын олборлолт ихээхэн хэмжээгээр явуулж буй улс орнуудынх** байгаа бол Тайвань болон Чех улсуудад ашигт малтмалын олборлолт нь барилгын материал болон гүний ус, багахан хэмжээний байгалийн хий болон газрын тосны үйлдвэрлэлээр хязгаарлагдаж байна.

Бүх геологийн албад нь ерөнхийдөө геологийн олон дэд салбарын асуудлуудыг хариуцаж буй бөгөөд энэ нь тухайн харьяалах яамны хариуцаж буй чиг үүргээс ч илүү өргөн хүрээг хамарч буй юм. Үүний тоонд:

- Эрдэс баялгийн нөөцийн хайгуулд дэмжлэг үзүүлэх геологийн мэдээллээр хангах;
- Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох, үйлдвэрлэл явуулах үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;
- Үндэсний ашиг сонирхол бүхий доорх болон бусад асуудлаар мэдээлэл, зөвлөгөө бэлтгэн хангах:
 - Газар/хөрсний тогтворжилт;
 - Хөдөө аж ахуй, газрын асуудлууд;
 - Гүний ус;
 - Инженерийн, барилгын, тээврийн дэд бүтэц; болон
 - Бохирдол болон байгаль орчны асуудлууд;
- Дээд боловсролын салбарт дэмжлэг үзүүлэх.

Шинээр байгуулагдах Үндэсний геологийн алба нь тухайн улс оронд нөлөөлж буй өргөн хүрээний геологийн холбогдолтой асуудлуудыг мөн хамрах ёстой.

8. Геологийн мэдээлэл – Эрх болон үүргүүд

Судалгаанд хамрагдсан геологийн албадын ихэнх нь өөрийн эрх мэдлийн хүрээнд газрын тос, ашигт малтмал болон бусад эрдэсийн хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд **геологийн мэдээллийг авах, архивлан хадгалах болон ашиглах (тодорхой нөхцлийн дагуу) хууль ёсны эрхийг** эдэлж байна. Энэхүү эрхийг үндсэндээ ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолтын үйл ажиллагааг зохицуулсан үндэсний, муж улсын хууль тогтоомжид заасан байдаг бөгөөд энэ нь тусгай зөвшөөрөл олгох үндсэн нөхцөл байдаг. Энэхүү эрхийг эрдэс баялгийн асуудал хариуцсан яам хариуцдаг.

Цаашид Уул уурхайн яамны харьяанд байгуулагдах Үндэсний геологийн алба нь гуравдагч талуудын цуглуулсан ашигт малтмал, газрын тос, нүүрс, гүний ус болон хэрэв боломжтой бол инженер геологийн бүхий л мэдээлэл, тайланг нэг дор нэгтгэн, цуглуулах, архивлах, ашиглах (зохистой байдлаар) эрхийг эдлэн, хэрэгжүүлж, үндэсний хэмжээнд геологийн мэдлэгийн тэргүүлэх байгууллага байх ёстой.

9. Геологийн албаны ур чадвар, чадавхи болон дэмжих үйлчилгээ

Судалгаанд хамрагдсан ихэнх геологийн албад нь **геологийн өргөн хүрээний, олон салбарын ур чадварыг эзэмшсэн** (далайн геологи, газар зүйн зураглал, биогeологи зэрэг нь Үндэсний геологийн албаны гол чиг үүрэгт хамаарахгүй тул орхисон) байна. Үүнд доорх сэдвүүд хамаарч байна:

Олон салбар/сэдвийн геологи	Чичирхийлэл судлал
Геофизик	Палеонтологи
Геохими	Хөрс судлал
Структур геологи	Мэдээллийн сангийн удирдлага
Сав газрын судалгаа шинжилгээ	Газар зүйн мэдээллийн систем
Гидрогеологи	Зайнаас тандан судлал
Инженер геологи	Ашигт малтмал, эрчим хүчний нөөцийн үнэлгээ
Геологийн гаралтай гамшиг	Байгаль орчны геологи

Дээрх хүснэгт нь геологийн судалгааны байгууллагад заавал байх ёстой ур чадвар, чиг үүргийн талаарх тодорхой ойлголтыг харуулж байна.

Дээр дурдсан бүхий л ур чадварыг Үндэсний геологийн алба эзэмшиж, хэрэгжүүлж байх ёстой.

Дэмжих үйлчилгээг энэхүү өргөн хүрээний чиг үүрэг, ур чадварын хүрээнд авч үзвэл судалгаанд хамрагдсан геологийн албад нь доор дурдсан үйлчилгээ болон дэмжлэг үзүүлэх чиг үүргийг гүйцэтгэж байна (алба бүрийн хамрах үйлчилгээ ялгаатай):

- Олон сэдэвт геологийн зураглал хийх
- Геологийн тоон болон аналог мэдээллийг архивлан хадгалах, удирдах
- Геохимийн мэдээлэл боловсруулалт
- Геологийн зураг гаргах
- Газрын тосны мэдээллийн удирдлага, боловсруулалт
- Үйлдвэр цех, засвар үйлчилгээ

- Геологийн мэдээлэл, үйлчилгээг зах зээлд ханган нийлүүлэх
- Санхүүгийн удирдлага
- Хүний нөөцийн удирдлага, хөгжил
- Вебд суурилсан дижитал үйлчилгээ хүргэх
- Топограф/картографын үйлчилгээ үзүүлэх
- Агаарын тандан судалгаа (гэрээгээр)
- Номын сангийн үйлчилгээ жишээ нь чулуун болон өрмийн дээжийг үзэх, судлах, дээж авах, шинжилгээ хийх боломжтой байх
- Лабораторын үйлчилгээ

Энэ нь мөн геологийн албанд байх ёстой дэмжих үйлчилгээ ямар байхыг бүрэн илтгэн харуулсан бөгөөд олон улсын хэмжээнд энэ чиглэлээр бүрэн хэмжээнд зөвшилцөл үүссэн болохыг харуулж байна.

Эдгээр бүхий л ур чадварыг Үндэсний геологийн алба эзэмшсэн байх шаардлагатай. Үндэсний геологийн албанаас бүс нутгийн, системтэй агаарын геофизикийн судалгаа явуулах чадамж нь төсвийн хязгаарлалтаас үүдэн боломжгүй байж болох ч энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх нь системтэй, орчин үеийн геологийн зураглалыг хийхэд томоохон түлхэц болж өгнө.

10. Загвар “геологийн алба” болон үүний “боломжит бүрэлдэхүүн хэсгүүд”

Судалгаанд хамрагдсан нийт 16 геологийн албаны загвараас харвал аль ч загварыг дангаар нь Монгол улсад шууд нутагшуулах боломжгүй юм. Гэхдээ Намиби болон Чех улсуудын геологийн албадын загварыг тусгасан загвар нь хамгийн түлхүү, ойр загвар байж болох бөгөөд энэ нь Монгол улсын Үндсэн хуулиар заагдсан шаардлагад илүү нийцэж, Монгол улсын ард иргэдийн хэрэгцээнд хамгийн сайнаар нийцэж болох юм. Үндэсний геологийн албаны энэхүү загвар нь Зураг 1 дээр харуулсан бүтэцтэй байж болно:

- **Эрх зүйн статус:** Уул уурхайн яамны удирдлагад ажилладаг, ашигт малтмалын болон газрын тосны зохицуулалт хариуцсан газруудын адил эрх зүйн статус бүхий хэлбэртэй. Монгол улсын нөхцөлд үүнийг **Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, төрийн захиргааны байгууллага** хэмээх ангилалд хамааруулж болно. Ерөнхийдөө тус байгууллагын бүтэц нь доорх байдлаар байж болно:



Зураг 1: Төрийн захиргааны байгууллага, ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлагын статус

Энэхүү статус нь Австрали, Ботсвани, Намиби болон Чех улсуудын геологийн алба болон бусад ихэнх улсуудын албадтай ижил төстэй юм.

- **Геологийн мэдээлэл, үйлчилгээний хэрэглэгчид:** Ашигт малтмал, газрын тосны асуудал эрхэлсэн яам, мөн бусад яам агентлагууд жишээ нь байгаль орчин, шинжлэх ухаан, инноваци,

батлан хамгаалах, аюулгүй байдал, дэд бүтэц болон хот байгуулалт хариуцсан яам, агентлагууд нь боломжит хэрэглэгчид байх бөгөөд мэдээлэлтэйгээр шийдвэр гаргахын тулд геологийн мэдээлэл тэдгээрт шаардлагатай юм. Бусад хэрэглэгчдийн тоонд төрийн бусад байгууллагууд жишээ нь гамшгийн бэлэн байдал/хариу арга хэмжээ, нөөцийн ашиглалт болон хөгжлийн байгууллагууд, дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбар, усны салбар, орон нутгийн захиргаад болон олон нийт байна.

- **Төрийн санхүүжилт болон бусад санхүүжилт:** Үндсэндээ ашигт малтмал, газрын тосны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний төсвийн багц болон гэрээний үндсэн дээр үйлчилгээ авах бусад яамд үүнд байгаль орчин, шинжлэх ухаан, инноваци, батлан хамгаалах, аюулгүй байдал, дэд бүтэц болон хот байгуулалт хариуцсан яам, агентлагууд нь боломжит санхүүгийн эх үүсвэр болно. Ашигт малтмалын хайгуул болон олборлолтын салбар нь мөн гэрээний дагуу авсан үйлчилгээндээ төлбөр төлөх ч геологийн суурь мэдээлэл үнэ төлбөргүй байх ёстой. Үүний нэгэн адил дэд бүтцийн бүтээн байгуулалтын салбар, усны салбар, орон нутгийн захиргаад нь өөрийн авч буй үйлчилгээнд төлбөр төлөх ч геологийн суурь мэдээлэл үнэ төлбөргүй байна. Их сургуулиуд болон олон нийт нь мэдээллийг үнэ төлбөргүй авах эрхтэй байна (хэрэв интернетээр дамжуулан авах боломжгүй бол хуулбарлах зардлыг төлөх байдлаар).
- Геологийн албаны нийт санхүүжилтэнд толгой байгууллагаас гадна бусад санхүүжилтийн эзлэх хувь хэмжээ: Дэлхийн туршлагаас харвал ойролцоогоор 30%.
- **Үндэсний геологийн албанаас үзүүлж болох үйлчилгээнүүд (Монгол улсын нөхцөлд далайн болон галт уулын аюул байхгүй):** Үндсэндээ энэхүү үйлчилгээнд шинжлэх ухааны зөвлөгөө, газрын тос, уул уурхай, нүүрс, усны салбар болон тэдгээрийн зохицуулах эрх бүхий байгууллагууд, хэрэглэгчдэд үзүүлэх дэмжих үйлчилгээ, үндэсний төлөвлөлт, гамшгийн эрсдлийг бууруулах, аюулгүй байдал, нийтийн хэв журам, барилгын салбарт үзүүлэх шинжлэх ухааны үйлчилгээ, геологийн салбарын хүрээнд дээд боловсролын салбарт үзүүлэх үйлчилгээ багтана.
- **Геологийн албаны эзэмшсэн байх геологийн суурь ур чадварууд:**
 - (a) Геологийн олон төрөл сэдэв
 - (b) Геофизик
 - (c) Геохими
 - (d) Структур геологи
 - (e) Сав газрын судалгаа
 - (f) Гидрогеологи
 - (g) Инженер геологи
 - (h) Геологийн гаралтай гамшиг
 - (i) Чичирхийлэл судлал
 - (j) Палеонтологи
 - (k) Хөрс судлал
 - (l) Мэдээллийн сангийн удирдлага
 - (m) Газар зүйн мэдээллийн систем болон зайнаас тандан судлал
 - (n) Хайгуул хийж буй нөөцийн үнэлгээ
 - (o) Байгаль орчны геологи
- **Геологийн алба эсвэл яамны үзүүлэх геологийн дэмжих үйлчилгээ:**
 - (a) Олон сэдэвт геологийн зураглал хийх
 - (b) Геологийн мэдээллийг дижитал байдлаар архивлах, удирдах

- (c) Геохимийн мэдээлэл боловсруулах, зураглал үйлдэх
- (d) Газрын тосны мэдээллийн удирдлага, боловсруулалт
- (e) Үйлдвэр цех, засвар үйлчилгээ болон үйлдвэрлэл
- (f) Геологийн маркетинг
- (g) Санхүүгийн удирдлага
- (h) Хүний нөөцийн удирдлага болон хөгжил
- (i) Вебд суурилсан дижитал үйлчилгээ үзүүлэх
- (j) Топограф/картографын үйлчилгээ
- (k) Агаарын тандан судалгаа (гэрээгээр)
- (l) Номын сангийн үйлчилгээ
- (m) Лабораторын үйлчилгээ

11. Гадаад орнуудын геологийн албад

Олон улсад геологийн албад нь үндсэндээ 5 загварт хамрагдаж байна.

Эдгээрт:

- Бие даасан төрийн байгууллага (4 жишээ)
- Яамны харьяа газар эсвэл агентлаг (6 жишээ)
- Агентлагын хэлтэс (2 жишээ)
- Шинжлэх ухааны институт (3 жишээ)
- Төрийн компани (1 жишээ)

Дээр дурдсан геологийн албад нэг бүрийг бид судлан, үнэлгээ хийсэн бөгөөд үйл ажиллагааны 13 гол салбарт хамааруулан судлан үзсэн:

- (a) Стратеги болон/эсвэл үйл ажиллагаа
- (b) Эрх зүйн статус; эсвэл хамаарах толгой байгууллага, геологийн албыг удирддаг яам эсвэл байгууллага, үйлчилгээг нь ашигладаг үндсэн талууд
- (c) Геологийн мэдээлэл, үйлчилгээний эцсийн хэрэглэгч нар
- (d) Геологийн албаны санхүүжилтийн эх үүсвэр- ЗГ эсвэл дээд байгууллага болон бусад нэмэлт эх үүсвэрүүд;
- (e) Нийт санхүүжилтэд толгой байгууллагын санхүүжилтээс бусад бүх санхүүжилтийн эзлэх хувь,
- (f) Үндэсний эдийн засаг (Дэлхийн Банкны ангилал болон эдийн засгийн үйл ажиллагааны төрөл)
- (g) Геологийн мэдээлэл болон зөвлөгөө шаардлагатай ашигт малтмалын хайгуул/үйлдвэрлэлийн асуудлууд, үндэсний хөгжлийн асуудлууд
- (h) Уламжлалт нөөц баялгийн салбараас гадуурх олон нийтийн сайн сайхан, аюулгүй байдалтай холбоотой асуудлууд
- (i) Геологийн мэдээлэл (гуравдагч тал) – Эрх болон үүргүүд
- (j) Геологийн албанд буй геологийн үндсэн ур чадвар
- (k) Тухайн албанаас үзүүлэх боломжтой геологийн дэмжих үйлчилгээ
- (l) Геологийн албаны гүйцэтгэлийн үнэлгээний тайлан байгаа эсэх
- (m) Гүйцэтгэлд хийгдсэн үнэлгээгээр гарсан дээд түвшний дүгнэлт (жишээ нь зардал-үр ашгийн харьцаа болон бусад баталгаажуулалт гэх мэт);

Дээр дурдсан гол салбар/асуудал нэг бүрийг геологийн алба бүр дээр тусган харуулсан.

11.1 “Бие даасан” төрийн байгууллага

➤ Австралийн геологийн алба

Австралийн геологийн алба нь Холбооны тогтолцоон дахь үндэсний геологийн алба бөгөөд тус албаны харьяанд мөн 6 мужийн геологийн алба өөрийн нутаг дэвсгэрийг хариуцан ажилладаг.

а) Стратеги

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлээр дамжуулан Австралийн геологийн алба нь олон нийтэд тогтвортой эдийн засаг, нийгэм, байгаль орчны үр дүнг хүргэхүйц хэрэглээний судалгааны мэдээллийг ханган нийлүүлдэг.

No.	Стратегийн тэргүүлэх чиглэл	Зорилт	Үүрэг роль	Стратеги	Хүлээгдэж буй үр дүн
1	Австралийн нөөц баялгийг бий болгох	Австралийн ашигт малтмал болон эрчим хүчний нөөцийн үр ашгийг одоо болон ирээдүйд дээд түвшинд хүргэх	Ашигт малтмал, эрчим хүчний потенциалыг бий болгосноор хайгуулын ажилд хийгдэх хөрөнгө оруулалтыг Австрали руу татах	<ul style="list-style-type: none"> • Австралийн ашигт малтмал, эрчим хүчний нөөцийг урьдчилан таамаглах чадавхийг хөгжүүлэх • Мэдээлэл цуглуулах, боловсруулах болон дүн шинжилгээ хийх замаар нээгдэх боломжтой ашигт малтмал, эрчим хүчний нөөц бүхий газар нутгийг тогтоох • Австралийн Засгийн газар болон бусад талуудад хараат бус, үнэн зөв мэдээлэл өгөх зорилгоор Австралийн ашигт малтмал, эрчим хүчний нөөцийг үнэлэх • Австрали улсын ашигт малтмал, эрчим хүчний нөөцийн потенциалыг сурталчлан дэмжих ажилд манлайлах 	<ul style="list-style-type: none"> • Австрали нь ашигт малтмал, эрчим хүчний нөөцийн хөрөнгө оруулалтын хувьд олон улсын хувд өрсөлдөх чадвар бүхий улс болох • Австрали улс нь шинэ орд газруудыг нээх замаар өөрийн ашигт малтмал болон эрчим хүчний нөөцийг тогтвортой хадгалах • Австралийн ашигт малтмалын нөөц нь тус улсын эдийн засагт хувь нэмэр оруулах • Ашигт малтмал болон эрчим хүчний нөөцийн удирдлагад олон нийтийн итгэлцэл бий болох
2	Австралийн олон нийтийн аюулгүй байдлыг хангах	Австралийн ард иргэд байгалийн аюулыг даван туулах, дасан	Байгалийн аюулыг даван туулах, зохицуулах Австрали улсын	<ul style="list-style-type: none"> • Байгалийн аюул, үүнд олон нийтийн өртөх байдлын талаар мэдлэг, ойлголт бий болгож, эрсдлийг бууруулах болон олон нийт даван туулах, дасан зохицох 	<ul style="list-style-type: none"> • Австрали улс нь эдийн засаг, нийгэм болон байгаль орчинд нөлөөлөх аюултай үзэгдлийг бууруулах үндэсний чадавхитай болох

		зохицох илүү чадвартай байх	чадавхийг бэхжүүлэх	<p>чадвартай болгоход дэмжлэг үзүүлэх</p> <ul style="list-style-type: none"> Эрсдлийг бууруулах болон олон нийтийн даван туулах, дасан зохицох чадварыг дэмжихэд нь Австралийн засгийн газарт үнэн бодит, хараат бус мэдээлэл, зөвлөгөөг өгөх Байгалийн гамшгийн бэлэн байдал, хариу арга хэмжээ болон сэргээн босголтын үр дүнтэй системийг бий болгон сайжруулах Австралийн гадаад улс орнууд дахь хөгжлийн хөтөлбөрт хувь нэмрээ оруулах 	<ul style="list-style-type: none"> Аюултай үзэгдэлд хариу арга хэмжээ авах, бэлтгэлтэй байхад мэдээлэлтэй шийдвэр гаргах Байнгын мониторинг болон урьдчилан сануулах тогтолцоог бий болгон, нөлөөллөөс хамгаалах
3	Австралийн усны баталгаат байдлыг хангах	Австралийн усны нөөцийн ашиглалтыг боловсронгуй болгож, удирдах	Австралийн гүний болон гадаргын усны тогтолцооны байршил, хэмжээ, чанар болон тогтвортой ашиглалтын талаар мэдээлэх	<ul style="list-style-type: none"> Гүний усны нөөц, процесс болон нөлөөллийн талаар Австралийн засгийн газарт үнэн бодит, хараат бус мэдээлэл, зөвлөгөөг өгөх Гүний болон гадаргын усны тогтолцооны талаар мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор олон сэдэвт, олон талыг хамарсан геологийн судалгаа, шинжилгээ хийх Гадаргын усны мэдээлэл, чанар болон түвшний талаарх мэдээллийг сайжруулах замаар усны урсацыг таамаглах боломжийг хангах 	<ul style="list-style-type: none"> Австралийн усны нөөцийн удирдлагад шинжлэх ухааны нотолгоог суурь болгох Олон нийт усны тогтвортой хүртээмжтэй байх Усны нөөцийн удирдлага, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар олон нийтийн итгэлийг бий болгох
4	Австралийн далайн	Австралийн далайн	Австралийн далайн хил	<ul style="list-style-type: none"> Австралийн далайн орон зайн мэдээллийн систем (AMSIS) нь 	<ul style="list-style-type: none"> AMSIS дээр харуулж буй далайн эргийн хил хязгаар нь үүнд тивийн хязгаар зэргийг

	эргийн нөөцийг удирдах	засаглал болон хамаарах хууль тогтоомжийг боловсронгуй болгох	хязгаарын тухай мэдээллийг нэгтгэн уялдуулах	вебд суурилсан, интерактив зураглал, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх систем бөгөөд далайн орчны тухай Засгийн газрын болон төрийн бус эх сурвалжуудын мэдээллийг нэгтгэн, сайжруулж байдаг систем юм.	НҮБ-ын далайн эрх зүйн тухай конвенци (UNCLOS) болон 1973 оны Далай болон усан доорх газрын тухай хуулийн дагуу тодорхойлон гаргасан байдаг. <ul style="list-style-type: none"> • Үүнд хамаарах мэдээлэл нь доорхтой холбоотой далайн орчин, геологийн мэдээллийг багтаадаг: <ul style="list-style-type: none"> ○ Газрын тос ○ Загас агнуур ○ Байгаль орчин ○ Хуулийн этгээд буюу Франц, Зүүн Тимор, Шинэ Зеланд, Папуа Шинэ Гвиней, Соломоны арлууд зэрэг улстай хийсэн гэрээ ○ Дэд бүтэц ○ Далайн тээвэр ○ Хүний үзүүлэх нөлөөлөл ○ Хамаарах бусад мэдээлэл
5	Геологийн суурь мэдээллээр хангах	Австрали тивд гарч буй процессын цаг хугацаа, байршил, өөрчлөлтийн талаарх ойлголтыг бий болгон байгалийн болон бүтээн босгосон орчинтой хамаарах шийдвэр	Газар зүй, геологийн талаар үндэсний хэмжээний, бодит, суурь мэдээллээр хангах	<ul style="list-style-type: none"> • Орон зайн мэдээллийн хүрээллийг бий болгон хэрэгжүүлж, Австралийн газар зүйн мэдээллийг гаргах • Төр болон олон нийтийн шийдвэр гаргалтад байршлын мэдээллийг ашиглалтаар тэргүүлэх • Үндэсний геодезийн чадавхийг бий болгох 	<ul style="list-style-type: none"> • Австрали нь үндэсний хэмжээний газар зүйн суурь мэдээлэл болон зураг, мэдээлэл, байршил зүйн мэдээлэл бүхий захиргааны эх сурвалжтай болсон байх, • Австрали улс нь байгаль болон бүтээн босгосон зүйлсэд гарч буй гео орон зайн мэдээллийг байнга цуглуулан, гарч буй өөрчлөлтөд мониторинг хийж байх

		гаргалтад дэмжлэг үзүүлэх			
6	Геологийн мэдлэг, чадамжийг бий болгох, хадгалах	Мэдлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, чадавхийг хадгалах, сайжруулах, төр, салбар болон олон нийт нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг бий болгох. Мэдээллийг шинэлэг байдлаар, дахин ашиглах боломжийг хангах замаар төрийн мэдээллийн үнэ цэнийг нэмэгдүүлэх.	Геологийн болон гео-орон зайн мэдээллийг цуглуулан, удирдаж, олон нийт болон бүх Австраличуудад одоо болон ирээдүйд ашиглах боломжийг нь хангах.	<ul style="list-style-type: none"> • Геологийн ажиглалт, судалгааны дэд бүтцийг бий болгон ажиллуулж, хөтөлбөрийн зорилтод дэмжлэг үзүүлж дүн шинжилгээ хийх. • Геологийн болон гео орон зайн мэдээллийг цуглуулан, олон нийт одоо болон ирээдүйд ашиглах хүртээмжийг нь бий болгох • Өндөр чадал бүхий тооцоолон бодох хэрэгслийг ашиглан геологийн мэдээллийг хөрвүүлэн, инновацийг бий болгох • Геологи болон түүний үр дүнгийн талаар олон нийтэд сурталчилж, мэдлэг бий болгох • Далайн эргийн газрын тосны мэдээлэл, дээжийг хадгалах үндэсний хадгалах байгууламжаар хангах. 	<ul style="list-style-type: none"> • Австралийн геологийн мэдээллийг цуглуулан үр дүнтэй удирдаж, хадгалах • Австралийн геологийн мэдээлэл, сан нь олон нийтэд хүртээмжтэй байж, мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломжийг хангасан байх. Үүнд: Австралийг хамарсан мэдээлэл, фото, агаарын зураг, геофизикийн мэдээлэл, чулуулгийн шинж чанар, стратиграф, гал түймэр болон үерийн мэдээллийг онлайн хэлбэрээр түгээх • Австрали улс нь геологийн суурь мэдээллийг цуглуулах байнгын дэд бүтэцтэй болох

б) Эрх зүйн статус; геологийн албыг удирддаг эрх бүхий яам эсвэл байгууллага болон үйл ажиллагаагаа тайлагнадаг газар болон үйлчилгээг хэрэглэгчид

Яам (Аж үйлдвэр/ Эдийн засаг)	Яам (Байгаль орчин)	Яам (Нөөц)	Яам (Шинжлэх ухаан)
Төрийн агентлаг (Үндэсний эдийн засгийн хөгжил)	Төрийн агентлаг (Шинжлэх ухаан)	Бие даасан агентлаг (Сайдад ажлаа тайлагнаж буй)	Төрийн өмчит эсвэл хувийн компани

с) Геологийн мэдээлэл, үйлчилгээний эцсийн хэрэглэгчид

Хамаарах яаманд зөвлөх (толгой яам)	Бусад яамдад зөвлөх, үйлчилгээ үзүүлэх	Олон нийтэд хандан мэдээлэл түгээх, үйлчилгээ үзүүлэх	Батлан хамгаалах, аюулгүй байдлын мэдээлэл/зөвлөгөө өгөх
Хувийн хэвшилд мэдээлэл/зөвлөгөө ханган нийлүүлэх	Бараа бүтээгдэхүүний асуудлаар төрд зөвлөгөө өгөх, үнэлгээ хийх	Дээд боловсролын салбарт дэмжлэг үзүүлэх	Төрийн өмчит компаниудад мэдээлэл/үйлчилгээ нийлүүлэх
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зохицуулах	Гарын тосны тусгай зөвшөөрлийг зохицуулах (оффшор)	Усны тусгай зөвшөөрлийг зохицуулах	Нүүрсний тусгай зөвшөөрлийг зохицуулах
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл дээр зөвлөгөө өгөх	Газрын тосны тусгай зөвшөөрөл дээр зөвлөгөө өгөх	Усны тусгай зөвшөөрөл дээр зөвлөгөө өгөх	Нүүрсний тусгай зөвшөөрөл дээр зөвлөгөө өгөх

д) Улсын төсвийн санхүүжилт болон/эсвэл геологийн албаны бусад санхүүжилт

